

ТОРГОХ ЯЛЫН ҮР НӨЛӨӨ, ПРАКТИКТ АНХААРАХ АСУУДАЛ

Д.Батцогт

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, хурандаа

Товч агуулга: Шүүхээс хорихоос өөр төрлийн ялыг оногдуулах, оногдуулсан ялыг хуулийн хүрээнд нэг мөр эдлүүлэх, хэрэгжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох, шуурхай гүйцэтгэх, улмаар уг ялын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр анхаарал хандуулах зайлшгүй шаардлага бий болсныг харгалзан практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорьсон болно.

Түлхүүр үгс: Ял, Торгох ял, хорихоос өөр төрөл, дүн шинжилгээ

Abstract: *In view of the urgent need to pay attention to the imposition of non custodial sentences other than the court, to serve the non custodial sentences within the framework of the law, to create a stable system of implementation and prompt execution, and thus to improve the effectiveness of the punishment, we intend to find a way to solve the problems in practice.*

Key words: conviction, penalties, types other than imprisonment, analysis

Монгол Улсад эрх зүйн шинэтгэл эрчимтэй өрнөж, зөрчил ба гэмт хэргийн үндсэн шинжийг нэг мөр ойлгох, тэдгээрт оногдуулах ял, шийтгэлийн төрлийг шинээр тогтоох талаар эрдэмтэн судлаачид төдийгүй төрийн эрх барих дээд байгууллагын төвшинд хэлэлцэгдэн Улсын Их хурлаас Эрүү, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Зөрчлийн тухай хуулиуд батлагдан хэрэгжиж эхлээд багагүй хугацаа өнгөрөөд байна. Ийнхүү гэмт хэрэг, зөрчлийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин шинээр бүрдэн хэрэгжиж байна.

Шинэчлэн батлагдсан “Эрүүгийн хууль”-ийн тусгай ангийн 20 зүйл, 425 заалтын 235 заалт буюу 55.3% нь торгох ял, 199 заалт буюу 46.8% нь зорчих эрхийг хязгаарлах ял, 65 заалт буюу 15.3% нь нийтэд тустай ажил хийлгэх ял, 42 заалт буюу 9.9% нь

эрх хасах ял оногдуулахаар тусгасан байна. Энэ нь хорих ялыг биечлэн эдлүүлэх явдлыг багасгахад анхаарч хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулахаар хуульчилсан байна.

Хорихоос өөр төрлийн ял нь үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлган, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримтлах хандлагатай болж байгаа энэ цаг үед бид хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтийг “ял шийтгэл гарцаагүй байх” зарчмын хүрээнд бүрэн биелүүлэх шаардлага тулгарч байна.

Практикт хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт зарим талаар хангалтгүй, хяналтын тогтолцоо сул, үр нөлөө багатай байгаа талаар алба хаагч, судлаачид илэрхийлсээр байна.

Сэдвийн судлагдсан байдал:

Хорихоос өөр төрлийн ялыг эрүүгийн эрх зүйн үүднээс манай эрдэмтэн судлаачид нилээдгүй судалсан байдаг ба тухайлбал, академич С.Нарангэрэл²¹, шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан²², Г.Совд²³, хууль зүйн доктор, профессор А.Лхагва²⁴, доктор, профессор Д.Баярсайхан²⁵, доктор, дэд профессор Д.Бадам,²⁶ Б.Алтангэрэл²⁷ нар өөрийн бүтээлдээ тусгаж өгсөн байдаг.

Харин тусгайлан 2015 оны Эрүүгийн хуульд тусгагдсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн судалгааны бүтээл цөөн байна.

Нэг. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онцлог

Манай улсад хэрэглэгдэж буй хорихоос өөр төрлийн ял гэх нэр томьёо нь дэлхийн улс орнуудад:

1. нийгэм-олон нийтэд тулгуурласан ял нь (community sentence, community based sentence)²⁸;

2. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэж буй сонгох ял (alternative sentence) ;

3. хорихоос өөр төрлийн ял (non-custodial sentence)-ын нэгэн адил хэрэглэгдэх нэгдмэл нэршил бүхий ойлголт²⁹ юм.

“Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл” болон “сонгох хувилбараар оноох ял шийтгэл” гэсэн

ойлголтууд зарчмын хувьд ижил утгыг илэрхийлнэ.

Сонгох хувилбараар оноох ял шийтгэл гэдэгт нийгэмд учруулсан аюул занал, хохирлын хэмжээг харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эдлэх ялыг нийгмээс тусгаарлахгүй хэлбэрийн ялаар орлуулан хэрэглэж буй төрийн албадлагын арга хэмжээг ойлгоно. Хорихоос өөр төрлийн ялыг дэлхийн ихэнх улсад нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх гэж нэрлэж байна.

Хорих ял нь хорихоос өөр төрлийн ялтай харьцуулахад дараах онцлогтой байдаг. Үүнд:

- хорих ялын хувьд эрхийн хязгаарлалтын хүрээнд, тодорхой хугацаагаар байлгах мөн чанарыг илэрхийлнэ. Хорих газарт хэрэгжүүлж байгаа хөдөлмөрийн үйл ажиллагаа нь чөлөөт сонголтын бус албадлагын хэлбэрээр явагдана. Хоригдлыг нийгмээс тусгаарлан хүмүүжүүлнэ гэдэг ялангуяа өнөөгийн нөхцөлд боломжгүй байгаа нь практикаас харагдаж байна.

- хорих ялд хүнлэг бус шинж чанар давамгайлна. Учир нь эрх чөлөөг хасах хугацааны дэглэмийг гол төлөв энэ хугацаанд ялтны зүгээс аливаа чөлөөт үйлдэл хийх боломжоор хязгаарлагдсан байна.

- хорих ялын агуулгыг бусад ял шийтгэлийн нэгэн адил гадны нөлөөнд өртөж буй түүний объект болох Үндсэн хуулиар тогтоосон хувь

²¹ Монгол Улсын эрх зүй ерөнхий анги УБ., 1996 он

²² “Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол” ялын тухай сургаал II боть УБ., 2014 он,

²³ “БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс”

.УБ., 1973 он.,

²⁴ “Монгол Улсын шүүхийн шийдвэр

гүйцэтгэх эрх зүй” УБ., 2004 он,

²⁵ “Харьцуулсан Эрүүгийн эрх зүй” УБ., 2012 он

²⁶ “Монгол Улсын Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй” схемчилсэн тайлбар УБ., 2003 он,

²⁷ “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: харьцуулсан судлал”. УБ., 2018 он

²⁸ Зарим судлаачид “нийгэмд үйлчлэх ял”, “нийтийн тусын тулд үйлчлэх ял” зэргээр нэрлэх нь бий.

²⁹ <https://www.gov.uk/community-sentences>.

хүний эрхийн байдлаар тодорхойлно. Хорих ял нь хоригдлын эрх зүйн байдалд дараах хэлбэрээр нөлөөлнө:

- ял эдлэх хугацаанд хоригдлын зарим эрх, эрх чөлөө бүрэн хязгаарлагдана (чөлөөтэй зорчих, сонгох сонгогдох эрх);

- ял эдлэх хугацаанд хоригдлын зарим эрх, эрх чөлөөнд тодорхой хугацаатайгаар хязгаарлалт тогтооно (хувийн халдашгүй байдал, захидал харилцаа);

- хорих ял эдэлж буй хоригдолд түүний хувийн зан байдалд нийцүүлэн зарим төрлийн эрх, үүргийг онцгой болзол нөхцөлтэйгөөр тогтооно (хувийн ариун цэврийг чанд сахих, хорих байрны дотоод журмыг дагаж мөрдөх, захидал явуулах, хүлээн авах г.м.).

Эдгээр хүчин зүйлс нь хорих ял эдэлж буй хоригдлын хүмүүжил, зан үйл, сэтгэл санаа, бие бялдар, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ түүнийг нийгэмшүүлэхэд хүндрэл үүсгэдэг байна. Учир нь нийгмийн зүгээс хорих ялыг гол төлөв эергээр хүлээн авдаггүй тул энэ нь хорих ангид ял эдэлсэн хоригдлын амьдралд насан туршийн “хар толбо” үлддэг.

Өнөөдөр эдгээр сөрөг үр дагаврыг даван туулах үр дүнтэй арга замын нэгд нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл зүй ёсоор тооцогдож байна. Учир нь хорих ялыг бодвол нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн хүмүүжлийн арга барил давамгайлна.

Хорихоос өөр төрлийн ял нь гэмт хэрэгтнийг шинэчлэн өөрчлөх буюу нийгэмшүүлэх, түүнчлэн үйлдсэн гэмт үйлдлийг засаж залруулах боломжийг илүү олгодог бөгөөд ялын уламжлалт онолын хандлага буюу

зөвхөн цээрлэл үзүүлж шийтгэх “хариу үйлдэл” үзүүлэх явдлыг эрс шүүмжилсэн, нийгэм-олон нийтэд ил тод, нээлттэй байх, тэдний оролцоо, дэмжлэг тусламжид тулгуурласан хэлбэртэй байхын зэрэгцээ эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэй ял эдлүүлэх тогтолцооны шинэ хэлбэр гэж үзэж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд юуны өмнө ял шийтгэлийн хэлбэрийг боловсронгуй болгох шаардлагатай. Учир нь өнөөг хүртэл гэмт хэрэг үйлдсэн хүнийг залхаан цээрлүүлэх, тарчлаан зовоох хэлбэрийн арга барил хууль сахиулах болон шүүхийн практикт бат бөх оршсоор байна. Иймд олон нийтийн зүгээс өнөөдөр эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг илүү хүнлэг, энэрэнгүй, ардчилсан хэлбэрт шилжүүлэх арга замыг тууштай эрэлхийлж эхэлсэн. Эдгээр арга замын нэг нь “нийгэмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл” буюу **“хорихоос өөр төрлийн ял”** юм.

“Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл” гэдэгт ялтны зарим эрхийг тодорхой болзол, нөхцөлтэйгөөр хязгаарлах замаар оноож буй ял шийтгэлийг ойлгоно. Уг ялыг тухайн этгээдийн хувийн зан байдал, зан үйл, ёс суртахууны төлөвшил, үйлдсэн гэмт хэргийн төрөл, нийгэмд учруулсан сөрөг үр дагавар, хохирлын хэмжээ, гэм буруугийн хэлбэр зэрэг олон хүчин зүйлсийг харгалзаж оногдуулна.

Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэлийн давуу тал:

1. хүнлэг ёсны үзэл санаа давамгайлсан;

2. ялтныг засаж хүмүүжүүлэх болон эргэн нийгэмшүүлэх боломжтой;

3. эдийн засгийн хувьд хэмнэлттэй зэрэгт оршино.

Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг олон улсын болон үндэсний хууль тогтоомж гэж ангилан авч үздэг.

Дээрх зохицуулалтаас гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ хэрэгжүүлэгч тогтоол гүйцэтгэгчийн хувьд нарийн тодорхойлж амьдралын туршлагатай, мэргэжлийн зохих бэлтгэлтэй, хувийн шинж чанараар тохирсон хүн байвал зохино хэмээн тусгайлан тодорхойлсон нь ихээхэн анхаарал татсан юм.

Эдгээрээс үзэхэд хорихоос өөр төрлийн арга хэмжээ авагдсан этгээдийн сэтгэл зүйн байдалд ихэд анхаарч тусгайлсан мэргэжилтэн, сэтгэл зүйч бэлтгэхээс гадна олон нийтийн оролцоо уг арга хэмжээнд зайлшгүй чухал гэдгийг ухамсарлуулах зорилгоор онол практикийн бага хурал, семинар, бусад арга хэмжээг байнга зохион байгуулж ажиллахыг мөн зөвлөжээ.

НҮБ-ын гишүүн орнууд эрүүгийн хууль тогтоомждоо дээр дурдсан зарчмыг баримталж, хорих ялаас татгалзаж хорихоос өөр төрлийн ялыг сонгон хэрэглэх, уг ялыг хэрэглэхдээ олон нийтийн оролцоог сайжруулж, зөрчил гаргагч этгээдийн нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг нэмэгдүүлж, эргээд нийгэмд хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, зөрчил гаргагч, хохирогч этгээдийн эрхийн хооронд зүй зохистой харьцааг хангаж, үндэсний хууль тогтоомж, нийгмийн шударга ёсны шаардлагад нийцүүлж хуульчлах шаардлагатайг дурдсан байгаа нь тус ялыг эдлүүлэх ажиллагааны тогтолцоог илэрхийлсэн гэж үзэж болох юм.

Тиймдээ ч хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүйг дэлхий нийт хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр

төрлийн ялыг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас нь шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримтлах хандлагатай байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 7 дугаар сарын А/198 дугаар тушаалыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/171 дүгээр "Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газрыг Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба (ХӨТЯЭА) болгон өөрчлөн зохион байгуулжээ.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх талаар харьяалах нэгжийг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, үйл ажиллагааны талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх, улсын хэмжээний статистик тоо бүртгэл, судалгааг нэгтгэн чиглэлийн хүрээнд дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх талаар харьяалах нэгжийг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх;

- Согтуурах, мансуурах донтой эмгэгтэй хүнийг албадан эмчлэх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх;

- Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх талаарх **гомдлыг** хянан шийдвэрлэх;

- Хорих ял эдлүүлэхийг хойшлуулсан, тэнсэн сулласан ялтанд хяналт тавих ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

- Хуульд заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа бусад байгууллагын ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

- Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх талаар гадаадын улс орнуудын туршлага судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

- Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээний талаар санал боловсруулах;

- Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд

- хүмүүжлийн нөлөө үзүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх зэрэг болно.

Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

Ялтан торгох ял оногдуулсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор, хэрэв хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй ба хугацаа дуусгавар болоход ялтан торгуулийг төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч торгуулийг төлж

барагдуулаагүй шалтгаан нөхцөлийг судалж, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж, ялтны саналыг харгалзан уг хугацаанд торгуулийг төлж барагдуулах хуваарь тогтоож болно.

Тогтоосон хуваарийг ялтан тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд торгох ялыг хорих ялаар солих тухай сануулж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна. Сунгасан хугацаа дуусмагц торгох ялыг хорих ялаар солиулах саналаа прокурорт даруй хүргүүлнэ.

Торгох ял шийтгүүлсэн хуулийн этгээд заасан хугацаанд шүүхээс оногдуулсан торгуулийг төлөөгүй тохиолдолд заасан хөрөнгөөс албадан гаргуулна.

Шийдвэр гүйцэтгэгч торгох ял шийтгүүлсэн хуулийн этгээдийн эд хөрөнгөөс шүүхээс оногдуулсан торгуулийг албадан гаргуулах ажиллагааг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дагуу гүйцэтгэнэ.

Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээлэлийн сан бүрдүүлэх, ашиглах журам³⁰-д зааснаар 4.4-т зааснаар зааснаар шийдвэр гүйцэтгэгч нь сар бүр ял шийтгүүлсэн этгээдийг дуудан ирүүлж, шүүхээс оногдуулсан торгуулийг тогтоосон хугацаанд төлж барагдуулах талаар тайлбар авна гэж тусгасан байдаг.

Торгох ялыг ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоодог боловч ялтан тухайн тогтоосон хугацаандаа нэг газар, байрандаа оршин сууж

³⁰ ШШГЕГ-азрын даргын 2017.09.07-ны А/234 А/103 дугаар тушаал

амьдардаггүй. Мөн орлого олох боломж нь хүртэл харилзан адилгүй болдог. Хөдөө орон нутаг 21 хоногоос илүү хугацаагаар ажиллах нь их байдаг.

Энэ нь Монгол улсын ерөнхий прокурорын тушаал³¹-аар батлагдсан аргачилсан зааварт торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавихдаа ялтантай сар тутам уулзаж, торгох ялыг биелүүлэхийг шаардаж, тэмдэглэл хөтөлсөн эсэхийг шалгадаг. Торгох ялаар шийтгэгдсэн хөдөө орон нутагт ажилладаг ялтнуудын зүгээс сар болгон ирэх нь хүндрэл бэрхшээлтэй байгаа тул шүүхээс тогтоосон хугацаанд торгуулийн ялаа сар бүр хэсэгчлэн төлөлт хийж байгаа тохиолдолд биечлэн ирэхгүйгээр байх хүсэлт гаргаж байгааг үндэслэн журамд нэмэлтээр зохицуулалт оруулах шаардлагатай байна.

Торгох ялтай ялтанд хилийн хоригийг Монгол Улсын иргэн гадаад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хуулийн 5 дугаар

зүйлд зааснаар ялтан тус бүрт хилийн хориг тавигддаг. Тухайн хуулийн дагуу ШШГЕГазрын даргын А/40 дүгээр тушаалын дагуу 3 хоногийн дотор ялтан тус бүрт хилийн хориг тавиулах мэдэгдэлийг гардуулж, тэмдэглэл үйлдэн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд хүргүүлдэг. Торгох ялыг эрүүгийн хуулинд торгох ялын хэмжээ нь нэг зуун нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна³² гэж заасан байдаг нь 450.000 төгрөгийн торгох ялаар шийтгүүлсэн ялтан нь шүүхээс ирээд 7-14 хоногийн дотор торгох ялыг төлж барагдуулах нь элбэг байдаг. Тухайн ялтан нь торгох ялыг төлж барагдуулсны дараа гадаад улс орон руу зорчих шаардлага гардаг. Гэтэл торгох ялыг дуусгавар болгосон тохиолдолд дууссан тогтоолыг шийдвэр гүйцэтгэгч үйлдэж, ахлах шийдвэр гүйцэтгэгч нь батлана. Гэтэл дууссан тогтоолыг заавал прокурорын хяналтаар давхар гарын үсэг зурагдаж хүчин төгөлдөр болж байна.

	Хэмжих нэгж	Хяналт тавьсан ялтан		Өсөлт, бууралт /хувиар/	Ял эдэлж дууссан		Өсөлт, бууралт /хувиар/
		2022 он	2023 он		2022 он	2023 он	
Хүн	Ялтны тоо	8928	9544	6.9%	7377	7979	7.9
	Мөнгөн дүн /тэрбум/	13.9	17.5	26.1%	8.1	10.3	27.5
Хуулийн этгээд	Хуулийн этгээдийн тоо	10	14	40.0%	2	5	1.5 дахин их
	Мөнгөн дүн /сая/	414.5	337.5	-18.6%	197.0	174.6	-11.4%

Энэ нь шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачалалыг нэмэгдүүлдэг. Мөн тухайн ялтны гадаад зорчих эрхийг сэргээх саналыг Хорихоос өөр төрлийн эдлүүлэх албанд явуулахдаа заавал хүчин төгөлдөр дуусгавар

болгосон тогтоол явуулахыг шаарддаг. Дуусгавар болгосон тогтоол 3 хоногийн дотор ахлах шийдвэр, гүйцэтгэгч болон прокурор хянагддаг тухайн торгох ялаар шийтгүүлсэн

³¹ 2020.02.05-ны А/13 дугаар ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар

³² Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 3.2

ялтны эрх зүйн байдал хөнддөг гэж үзэж байна.

Хуулийн этгээдэд торгох ялыг оногдуулсан тохиолдолд хуулийн этгээдийн эд хөрөнгөөс албадан гаргуулна гэсэн хуулийн зохиоцуулалт оруулсан байна. Шинэчлэн найруулсан эрүүгийн хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн жил ирэх тусам торгох ялын биелэлт өссөн байна. 2023 онд

ДҮГНЭЛТ

Дээрх харьцуулсан судалгааг хийсний үндсэн дээр дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Орчин үед хүний эрхийн үнэт зүйлсийг хамгаалах шаардлагаас үүдэн ялын бодлогод хүмүүнлэгийн шинжтэй тогтолцооны өөрчлөлт гарч, олон улс орон хорихоос өөр төрлийн ялын төрлүүдийг /60-65%/ түлхүү хэрэглэх болсон байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210 дугаар зүйлд зөвхөн хорих ял эдэлж байгаа тусгай эрхийг, 211 дүгээр зүйлд тусгай үүргийг тусгаж өгсөн бөгөөд хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа ялтны тусгай эрхийг тусгасан заалт байхгүй байна.

Хорихоос өөр төрлийн ялаар сүүлийн 5 жилд 8069 хүн буюу нийт ял шийтгэлийн 21,4 хувийг эзэлж байгаа бөгөөд жилд дунджаар 1613 хүн хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн байна. Хорихоос өөр төрлийн ялын бодлогын хувьд

торгох ял шийтгүүлсэн 9544 ялтан, 14 уулийн этгээдэд холбогдох 17.8 тэрбум төгрөгийг биелүүлэхээс 7979 ялтан, 5 хуулийн этгээдэд холбогдох 10.5 тэрбум төгрөгийг биелүүлж, хяналтад 1565 ялтан, 9 хуулийн этгээдэд холбогдох 7.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бодит биелэлтийг өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 2.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

манай улс энэ төрлийн ялыг шүүхийн практикт маш бага, хязгаарлагдмал байдлаар хэрэглэж байгаа нь тухайн этгээдэд тохирсон байх зорилго чиг үүргийг хангаж чаддаггүй байна. Түүнчлэн ихэнхи тохиолдолд нэмэгдэл ялын чанартай хэрэглэдэг боловч хувь этгээдийн хувийн онцлогийг харгалзаж үздэггүй, хохирогчийн учирсан бодит хохирлыг шийдвэрлэхгүй орхидог зэрэг нь хорихоос өөр төрлийн ялын хувьд шийдвэрлэх ёстой тулгамдсан асуудал болоод байна.

САНАЛ

Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтны эрх үүргийг тусгах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэл өөрчлөлт оруулах

Торгох ялаар шийтгүүлсэн этгээдүүдэд гадаадад зорих эрхийг түдгэлүүлэхдээ торгох ялын үнийн дүнгээс хамаарч хилийн хориг тавиулах талаар журманд өөрчлөлт оруулах

**ЭХ СУРВАЛЖИЙН
ЖАГСААЛТ**

Хууль тогтоомжууд:

1. Эрүүгийн хууль 2002 он

2. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 2015 он

3. Дэлхийн эрүүгийн загвар хууль 2007 он

Олон улсын гэрээ,

конвенциуд:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1946 он

Судалгааны тайлан:

1. ШШГЕГ-ын ХӨТЯЭГазрын жилийн эцсийн тайлан, мэдээ 2016 он

2. ШШГЕГ-ын ХӨТЯЭГазрын жилийн эцсийн тайлан, мэдээ 2017 он

3. ШШГЕГ-ын ХӨТЯЭГазрын жилийн эцсийн тайлан, мэдээ 2018 он

4. ШШГЕГ-ын ХӨТЯЭГазрын жилийн эцсийн тайлан, мэдээ 2019 он

5. ШШГЕГ-ын ХӨТЯЭГазрын жилийн эцсийн тайлан, мэдээ 2020 оны 04 дүгээр сарын тайлан

Веб сайт:

1. www.legalinfo.mn
2. www.legislationline.org
3. <https://www.gov.uk/courts-and-tribunals/magistrates-courts/magistrates-courts-sentences>